

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ НАСЖИЛТ, НАСТНЫ ЭРҮҮЛ

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2018 ОНЫ ТАЙЛАН

Өмнөговь аймаг

2018.11.30

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл
1.	"Эрүүл насжилт, настны эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр Хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ. I үе шат 2014-2017 он II үе шат 2018-2020 он	Хүн амын эрүүл, идэвхтэй насжилтыг дэмжин, настны эрүүл мэнд, халамж, хамгаалал, нийгмийн оролцоог сайжруулан настны амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино.
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв, Олон улсын байгууллагын хандив тусламж, Эрүүл мэндийг дэмжих сангийн төсөвт тусган санхүүжүүлнэ.
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БОЭТөв, Сум, ӨЭМТ-үүд, СДЭ Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар болон бусад мэргэжлийн байгууллагатай бүх шатны Засаг дарга хамтран хэрэгжүүлнэ.
4.	Хөтөлбөрийн зорилтууд	1. Хүн амын эрүүл насжилтыг дэмжих хууль эрх зүй, нийгэм, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх; 2. Настны эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх; 3. Настны хөгжил, хамгаалал, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх; 4. Эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг настны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өргөжүүлэх.
5.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Зорилтуудыг хэрэгжүүлэхээр хийсэн ажлын биелэлт:

<p>Зорилт 1.</p> <p><u>Хүрэх үр дүн</u></p> <p><u>Хүрэх үр дүн:</u></p> <p>1. Хүн амын эрүүл насжилтыг дэмжих салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх эрх зүйн орчин бүрдэн, төрийн бодлого шийдвэрийг үе шаттайгаар хэрэгжүүлснээр хууль эрх зүй, нийгэм, эдийн засгийн таатай орчин бүрдэнэ.</p> <p>2. Нийгмийн зүгээс настанд хандах эерэг хандлага бэхжинэ.</p> <p>3. Настны хөгжил, хамгаалал, нийгмийн амьдралын оролцоо сайжирсан байна.</p> <p>4. Хүн амын эрүүл насжилтыг дэмжих, настанд ээлтэй дүүрэг, сум, хороо, баг, аж ахуйн нэгж, байгууллага, ажлын байр, зам, талбай бий болно.</p> <p>5. Хүн амыг эрүүл насжилтын талаар нотолгоонд тулгуурласан мэдээллээр хангах, судалгаа, сургалт, мэдээллийн тогтолцоо бүрдсэн байна.</p>	<p>2018 онд “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” хөтөлбөрийн төлөвлөгөөг 4 зорилтийн хүрээнд 14 арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэн ажилллаа.</p> <p>Ахмад настнуудын эрүүл мэндийг дэмжих, “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” хөтөлбөрийг хэрэгжүүлэн эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, холбогдох байгууллагын хамтын ажиллагаа, оролцоо, түншлэлийг өргөжүүлэх зорилгоор “Өглөөний цай” уулзалтыг зохион байгуулан 8 байгууллагын оролцоог хангаж ажилласан. Уулзалтын үр дүнд Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн ахмадын кабинетийг тохижуулан ээлтэй орчин бүрдүүлсэн.</p> <p>Аймгийн Засаг даргын тамгийн газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Геронтологийн үндэсний төв хамтран “Эрүүл мэндийг дэмжих жил”, “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрээнд “Эрүүл насжилтын төлөө хамтдаа” үйл ажиллагааг Далангадгад суманд 2018 оны 04 дүгээр сарын 23,24-ны өдрүүдэд зохион байгууллаа. Геронтологи, гериатрийн үндсэн ойлголт, орчин үеийн оношлогоо, эмчилгээний чиг хандлага” сэдэвт эмч эмнэлгийн мэргэжилтний сургалт зохион байгуулан 70 орчим эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа. БОЭТ-ийн ахмадын кабинет, ӨЭМТ-үүдэд Геронтологи, гериатрийн чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, настанд ээлтэй орчин бүрдүүлсэн байдалд үнэлгээ өгч хамтран ажиллаа. Аймгийн ахмадын хороотой хамтран нийт 170 ахмадад “Дэлхий дахины насжилтын чиг хандлага ба эрүүл насжилт”, “Настны эмийн зохистой хэрэглээ” сэдэвт сургалт зохион байгуулсан. 15 сумын настнуудын дунд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 615 ахмад хамрагдлаа. Бүсийн оношилогоо эмчилгээний төвд ахмадад мэдрэл, дотор, дотрын ЭХО, зүрх судас, зүрх судасны ЭХО, үе мөч, нөхөн сэргээх эмчилгээг хийж, зорилтод 60-аас дээш насны ахмадыг эмгэг судлалын судалгаанд хамруулсанаар нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт, бодлогын бичиг баримт боловсруулахад шаардлагатай мэдээллийг нэгтгэж ажилласан.</p> <p>Аймгийн засаг даргын а/480 захирамж “Ахмадад ээлтэй сум, байгууллага шалгаруулах” журмыг батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг журмын дагуу материал ирүүлсэн байгууллага 5 байна.</p> <p>Дэлхийн эмч нарын баярын хүрээнд Тэгш дүүрэн эмнэлгийн уламжлалтын эмч судалгааны ажил бичиж ахмадын дунд зонхилон тохиолдох өвчин эмгэг, түүний эмчилгээний арга барил сэдвээр бусад эмч нарт судалгааны ажлаа танилцуулан хуваалцсан.</p> <p>ХХҮГ-тай хамтарч Эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд ахмад настны эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, эрүүл аж төрөх ёсны боловсрол олгох, зорилтод бүлгийн иргэнийг хэнийг орхигдуулахгүй байх зарчимд тулгуурлан ахмад насны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хууль тогтоомжийн талаарх мэдээлэл, сургалт, сурталчилгааг 15 байгууллагын тэтгэвэрт гарах болон тэтгэвэрт гарсан ахмадуудад зохион байгуулан нийт 450 орчим хүнд хүрсэн.</p>
<p>Зорилт 2.</p>	<p>Ахмадын кабенит нь 2018 оны 11 сарын байдлаар нийт үзлэг 3603 үүнээс өвчний учир</p>

<p><i>Хүрэх үр дүн:</i></p> <p>1. Эрүүл зан үйл, амьдралын хэв маягийг хэвшүүлж, осол, гэмтэлд өртөх эрсдэлийг бууруулж, Монгол хүний эрүүл, урт наслалтыг дэмжсэнээр дундаж нас уртасна.</p> <p>2. Хүн амын хорт зуршлын хэрэглээ буурна.</p> <p>3. Эмийн зохистой хэрэглээний түвшин нэмэгдэнэ.</p>	<p>2365 урьдчилан сэргийлэх 588 идвэхтэй хяналт 650 үзлэг хийж кабинетаар болон 2-р шатлалд явуулж нийт шинээр 9 хорт хавдар оношлогдсон. Хоол тэжээлийн дутагдалд орох эрсдэлтэй настанд хооллолтын зөвөлгөө жингийн илүүдэлтэй хүмүүст илүүдэл жин бууруулах дасгал хөдөлгөөнийг заасан. Уламжлалт эмчилгээний кабениттай хамтран ахмадуудад клиникийн нөхөн сэргээх эмчилгээг хийж байна. 11 ЭМТ-д 3 СДЭ, 4 ӨЭМТ-үүд Ахмад настны “Өөрийгөө асрах чадварын судалгаа”-г 2800 орчим ахмадад хийж, эрүүл мэндийн зөвөлгөө өгч ажилласан байна. Эрүүл мэндийн салбарийн ахмад ажилчиддаа хүлээн авч, эмнэлгийн тусламжинд хамруулан 120 орчим ахмад хамрагдсан.</p> <p>БОЭТ нь Даланзадгад сумын 8 багтай хамтарч Ахмадын 1 өдөр зохион байгуулж, 516 ахмадуутай уулзалт ярилцлага хийж, шаардлагатай ахмадуудад нүдний үзлэг, хэвлийн ЭХО оношлогоо, эрт илрүүлгийн үзлэг хийж, Эмийн хөнгөлөлт ба эмийн зохистой хэрэглээ сэдвээр сургалт хийж гарын авлага тараан витаминжүүлж, үзлэг шинжилгээнд 162 ахмад хамрагдсан байна.</p> <p>Ахмад настны онцлог өвөрмөц хэрэгцээнд зориулан нийгмийн халамжийн сангаас хиймэл шүд-150, гар таяг-60, сонсголын аппарат-50 харааны шил-200, Нүдний уян болор-9 ахмад, асран хамгаалагчийн тэтгэмжийг 298 хүнд тус тус олгосон.</p> <p>Ахмадын нийгмийн халамжийн цогц тусламж үйлчилгээ сургалтыг НХҮХ, ЭМГ хамтран зохион байгуулж 250 орчим ахмад хамрагдсан.</p> <p>Насжилтын тухай эрүүл мэндийн сурталчилгааны 4 төрлийн материалыг 2000 хувилж, өндөр настанд тарааж, эрүүл мэндийн сурталчилгаа зөвлөгөө өгсөн.</p> <p>Сэврэй сумын ЭМТ хонгорын элсний амралтын газрыг түшиглэн ахмадын сувилал ажиллуулж 25 ахмадыг хамруулж цогц тусламж үйлчилгээ үзүүлж сувилж амруулсан.</p> <p>15 сумын байнгын асаргаатай, хэвтэрийн ахмад настны гэрийн эргэлт, эмнэлгийн тусламж үйлчилгээг ойртуулах зорилгоор 10-11 саруудад эрүүл мэндийн байгууллагууд, хөдөлмөр халамжийн мэргэжилтэнтэй хамтарч үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан. Уг арга хэмжээний үр дүнд нийт 360 ахмад хамрагдаж, шинээр 16 ахмад халамжид бүртгэгдэж, эмчилгээ үйлчилгээг цаг алдахгүй авч чадсан байна.</p> <p>Эрүүл мэндийг дэмжих зилийн хүрээнд Даланзадгад сумын 8 багийн ахмад настны эрүүл мэндийг дэмжих, чийрэгжүүлэх өглөөний дасгал брэнд арга хэмжээг аймгийн ЗДТГ, НБХ, ХХҮГ, БТСГ-тай хамран хэрэгжүүлэ байна. Уг арга хэмээнд өдөрт 70-90 ахмад хамрагдаж уг үйл ажиллагааг дэмжиж байна.</p>
<p>7. Дүгнэлт, санал</p>	<p><i>Хөтөлбөр хэрэгжүүлэх явцад гарсан ололттой талууд:</i> Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймгийн Засаг дарга болон НБХэлтэс анхаарлаа</p>

		<p>хандуулан дэмжлэг бүхий л талаар үзүүлэн хамтарч ажиллаж байгаа нь их ололттой байлаа. Эрүүл насжилт, настны эрүүл мэнд хөтөлбөрийн 2,4-р зорилт ЭМБ-т, 1,3-р зорилт нь ХХҮГ-т хэрэгждэг.</p> <p>Хөтөлбөр хэрэгжүүлэх явцад гарсан дутагдалтай талууд:</p> <p>Ахмад настны эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулахад ЭМГ-ын ахмад настны эрүүл мэндийг хариуцсан мэргэжилтэн болон БОЭТ-ийн ахмадын эмчийг чадваржуулах сургалтуудад хамруулах, ахмадын эрүүл мэндийн хэрэгцээг тодорхойлсон судалгааг гаргах, ахмадын эрүүл мэндийн хөтөлбөр хариуцсан байгууллага бүрийн хамтын оролцоо сул байгаа нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна.</p>				
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ					
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Дундаж биелэлт
			3	98%	98%	98%

Хэрэгжилт гаргасан: Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн

Б.Ганцэцэг